



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A/16

Онги

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Найз багийн нутаг “Галт Хайрхан” гэх газарт нутаглаж буй малчин Ж.Мягмарсүрэнгийн суурьт Бог малын мялзан өвчний шинж тэмдэг бүдгэрч эдгэрсэнтэй холбогдуулан 2023 оны 02 дугаар сарын 24-ны өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаанд тогтоосон хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Сумын Онцгой комисс шуурхай хариу арга хэмжээ авч дээрх бүс нутагт хязгаарлалтын дэглэм тогтоож, хяналтын пост гарган ажилласны үр дүнд халдварт тархаагүй, өвчлөл дахин илрээгүй болохыг тухайн бүс нутаг дэвсгэрт нутаглаж буй малчдад мэдэгдсүгэй.

3. Малчдын мэдээллээр хангаж тухайн бүс нутаг дэвсгэрийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт, Малын гоц халдварт мялзан өвчинөөс сэргийлэхийг малчдад, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын их эмч нар болон Мал эмнэлгийн тасагт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.АМОРСАННАА